



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**Хамрагдсан байгууллага:** СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

**Тайлангийн код:** СХШУДАГ-2026/ДА/02

Сүхбаатар хот  
2026 он

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1. Байгууллагын тухай .....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ .....	2
2.1. Аудитын зорилго .....	2
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт .....	3
2.3. Аудитын арга, аргачлал .....	3
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА .....	3
3.1. Засаглалын удирдлагын талаар .....	4
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар .....	4
3.3. Дотоод хяналтын талаар .....	4
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР .....	4
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт; .....	6
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт; .....	6
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт; .....	7
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах; ...	7
5. АУДИТЫН ҮР ДҮН .....	8
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....	9

## 1. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 “Яам нь харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.” Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Сүхбаатар аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу Нийтийн номын сангийн 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, Ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор, Ахлах мэргэжилтэн Ч.Одгэрэл нар 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

### 1.1. Байгууллагын тухай

Жавхлант шарга аймгийн даргын шийдвэрээр 1947 онд Гэгээрлийн хэлтсийн харьяанд 1 орон тоотой, 300 гаруй номтойгоор анх номын сан байгуулагдсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Монгол Улсын Төрийн эрхэм дээд-Тэргүүн зэргийн шагнал Чингис хаан одонт, Соёлын гавьяат зүтгэлтэн Дэлхийн Урлаг Соёлын Академийн дэд ерөнхийлөгч, Зохиолч яруу найрагч Гомбожавын Мэнд-Ооёогийн нэрэмжит болон үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Жаахан шарга театрын байранд 2008 оноос хойш үйлчилгээний 4 танхим, 150 хүний суудалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын регистрийн дугаар 9053824, Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны 100120035022, нэмэлт санхүүжилтийн 100120035011 дугаар харилцах дансаар бэлэн бус төлбөр, тооцоог хийсэн.

Аудитад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг 2024 оны 07 сарын 16-ны өдрөөс эхлэн дарга Э.Амарбат, хоёрдугаар гарын үсгийг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс нягтлан бодогч Ш.Батсүрэн нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан байна.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1. Аудитын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийн, дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

## 2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Үүнд.

- Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;
- Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;
- Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;
- Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах;

Хязгаарлалт: Дээрх асуудлаас бусад үйл ажиллагааг хязгаарласан болно.

## 2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгосон. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт

## 3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Сүхбаатар аймгийн идэвхтэй уншигчийг дэмжих, номын ач холбогдлыг ойлгуулж, номтой нөхөрлүүлэх замаар тэдний хүмүүжил төлөвшилд нөлөөлөх хандлагыг өөрчлөх зорилгоор оны шилдэг уншигч шалгаруулах “Судар эгшиглэн” төслийг хэрэгжүүлэн зургаа дахь жилдээ амжилттай зохион байгуулан ажилласан байна. Төслийн үр дүнд идэвхтэй оролцогчдын тоо 5400 байсан бол 2025 онд 16523 болж өргөжсөн байна.

Мөн хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх “Бяцхан номын санчид” дугуйлангийн сурагчдын хамт цэцэрлэгүүдэд “Гахайн гурван тоорой” үлгэрийн номоор дүрийн тоглолт хийж 11 цэцэрлэгийн 40 бүлгийн 1100 цэцэрлэгийн хүүхэд багачуудад танхимаар хамрагдсан байна.

### 3.1. Засаглалын удирдлагын талаар

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 415 дугаар тушаалаар номын сангийн үлгэрчилсэн дүрэм баталсан бөгөөд үүний дагуу “Нийтийн номын сангийн дүрэм”-ийг 5 бүлэг 35 заалттай байхаар захирал 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр баталсан байна. Тус дүрмийн 1.1-д *“Аймаг, нийслэлийн нийтийн номын сан нь бие даасан үйл ажиллагаатай, иргэдэд ном, хэвлэл мэдээллээр үйлчлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах үүрэг бүхий орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллага мөн”* гэж заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар 93 хувь дүгнэсэн байна.

Хууль эрх зүйн хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 25, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 25 нийт 50 тушаал шийдвэрийг төлөвлөн гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэг”-ийн нэгдсэн дүнгээр 71 хувьтай дүгнэгдсэн байна.

Захирлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Нийтийн номын сангийн бүтэц орон тоог батлах тухай” А/159 дүгээр тушаалаар 14 хүний орон тоотой байхаар баталсан байна. Аудитад хамрагдах хугацаанд 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

### 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй. Нийтийн номын сан нь өөрийн гэсэн бие даасан байргүй Жаахан шарга хөгжимт театрын байранд 2008 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Уг барилга нь “Номын сангийн орчны үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742:2019” стандартыг хангахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гарсан. Ном болон номын тавиурууд эхнээсээ хөгц мөөгөнцөрт идэгдэх эрсдэл бий болсон байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 8 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

### 3.3. Дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан *“Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”*-ын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх эрх бүхий дотоод хяналтын ажлын хэсгийг захирлын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд нийт 11 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гаргасан боловч хэрэгжилтийг тооцоогүй байна. Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ удирдамж боловсруулан батлуулсан байна.

## 4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал: Байгууллагын санхүү байдлын тайлангаар нийт хөрөнгө 2025 онд 218,456.0 мянган төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлан Хүснэгт 1 (мянган төгрөг)

Үзүүлэлт	2025 оны 12 сарын 31		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/
1	2	3	4
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	12,168.8	12,893.8	725.0
Үндсэн хөрөнгө	210,500.3	205,562.1	(4,938.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>222,669.2</b>	<b>218,456.0</b>	<b>(4,213.2)</b>
Нийт өр төлбөр	0	0	0
ЗГ-ын оруулсан капитал	222,669.2	218,456.0	(4,213.2)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн</b>	<b>222,669.2</b>	<b>218,456.0</b>	<b>(4,213.2)</b>

Үйл ажиллагааны санхүүжилтийн талаар:

Байгууллагын төсвийг нийт 485,662.3 мянган төгрөгөөр баталсан. Үүнээс улсын төсвөөс 465,813.6 мянган төгрөг, орон нутгаас 8,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Гүйцэтгэлээр 474,313.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсөвт хөрөнгийн зарцуулалтын талаар:

Төсвийн гүйцэтгэл Хүснэгт 2(мянган төгрөг)

№	Эх үүсвэр	2025 оны 12 сарын 31		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>485,662.3</b>	<b>474,313.6</b>	<b>97.6</b>
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>477,162.3</b>	<b>474,633.6</b>	<b>97.7</b>
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>423,476.8</b>	<b>420,969.4</b>	<b>99.4</b>
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,257.4	349,257.4	100
4	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	43,657.0	43,657.1	100
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	
6	Хангамж, бараа материалын зардал	5,650.2	5,620.2	100
	Эд хогшил урсгал зардал	12,066.4	12,066.4	100
	Томиллолт зочны зардал	1,500.0	1,494.6	99.6
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,500.0	5,000.0	66.6
8	Бараа үйлчилгээний бусад зардал	3,845.8	3,843.7	99.5
9	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	53,685.5	53,664.2	99.9
	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	30,783.9	16,963.8	100
10	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	477,162.3	465,813.6	97.6
11	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	477,162.3	465,813.6	97.6
12	Улсын төсвөөс санхүүжих	477,162.3	465,813.6	97.6
13	Үйл ажиллагааны орлого			
14	Туслах ажиллагааны орлого			
15	Оны эхний үлдэгдлээс санхүүжих			
16	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,500.0	8,500.0	100

4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 12,168.8 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 12,893.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал

Хүснэгт 3 (мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэргийн материал	434.0	3,310.6	3,310.6	434.0
2	Аж ахуйн материал	4,940.9	7,677.1	7,367.1	5,250.9
3	Шатахуун	0	450.0	450.0	0
4	Бусад хангамжийн материал	6,793.9	5,077.2	4,662.2	7,208.9
<b>Дүн</b>		<b>12,168.8</b>	<b>16,515.0</b>	<b>15,790.0</b>	<b>12,893.8</b>

Нийт бараа материалын 55.9 хувийг бусад хангамжийн бараа материал, 40.7 хувийг аж ахуйн материал, үлдсэн 3.4 хувийг бусад бараа материал эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 16,515.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 15,790.0 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэн зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 294,114.2 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 205,562.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт 4(мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Машин тоног төхөөрөмж	100,851.2	2,566.4	-	103,417.6	61,997.6	41,419.9
2	Тавилга эд хогшил	41,689.4	2,000.0	-	43,689.4	32,773.3	10,916.1
3	Номын фонд	146,021.5	6,363.0	-	152,384.5	-	152,384.5
4	Бусад биет бус хөрөнгө	2,456.0	-	-	2,456.0	2,456.0	0
5	Программ хангамж	3,096.0	-	-	3,096.0	2,254.4	841.6
<b>Дүн</b>		<b>294,114.2</b>	<b>10,929.4</b>	<b>-</b>	<b>305,043.6</b>	<b>99,481.1</b>	<b>205,562.1</b>

Нийт хөрөнгийн 74.1 хувийг ном, 20.1 хувийг машин тоног төхөөрөмж, 5.3 хувийг тавилга эд хогшил, үлдсэн 0.5 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 7,066.6 мянган төгрөг, хандиваар 3,862.8 мянган төгрөгийн хөрөнгө авсан байна. Үүнээс машин тоног төхөөрөмж 2,566.4 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,000.0 мянган төгрөг, ном 6,362.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Нийт 10,929.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан. Акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй.

4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 4 нэр төрлийн алдаа зөрчил илэрч 2 акт, 2 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

Төрийн аудитаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж

Хүснэгт 5 (мянган төгрөг)

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн байдал
Акт	Бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	429.0	Төрийн сан хүү торгуулийн дансанд 2025.05.29-ний өдөр тушааж, зөрчлийг арилгасан. Давсан гаргаагүй байна.
Акт	Цалингийн нэмэгдэл илүү тооцож олгосон.	648.4	Төрийн сан хүү торгуулийн дансанд 2025.05.29-ний өдөр тушааж, зөрчлийг арилгасан. Давсан гаргаагүй байна.
Зөвлөмж	Санхүүгийн тайланд 990.0 мянган төгрөгийг өр төлбөр тусгаагүй.	990.0	Тооцоо нийлсэн үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулж тусгасан байна.
Зөвлөмж	Худалдан авсан номын баримт бүртгэл дутуу. Анхан шатны баримтаар баталгаажуулах.	-	Анхан шатны бүрдлийн хангаж баримтжуулсан байна.
	Нийт	2,067.4	

4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээ хугацаа хоцроосон.

Тус байгууллага нь Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 13 тушаалаар нийт 11,908.8 мянган төгрөгийн зардал гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалын хавсралтаар “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийг баталсан.

Дээрх аргачлалын дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн хуваарилалт батлах тухай” А/212 дугаар тушаалаар төсвийн хуваарилалтыг баталж, тайлант онд нийт 6,416.0 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилт авсан.

Гүйцэтгэлээр 6,416.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулалтыг авч үзвэл 2,566.4 мянган төгрөгөөр компьютер, 1,924.8 мянган төгрөгийн бараа материал, 2 албан хаагчид 862.4 мянган төгрөгийн түлээ нүүрс хөнгөлөлт, 1 албан хаагчид 100.0 тусламж, 4 албан хаагчид 962.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн зарцуулалтаар илэрсэн алдаа дутагдал илрээгүй болно.

## 5. АУДИТЫН ҮР ДҮН

<b>Илэрсэн асуудал 1</b>	Жижиг мөнгөн сангийн дансгүй, үйлчилгээний орлогыг бэлнээр хүлээн авч, төвлөрүүлдэг. Төлбөрт үйлчилгээний орлого 278.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Жижиг мөнгөн сангийн дансгүй, үйлчилгээний орлогыг бэлнээр хүлээн авч, төвлөрүүлдэг. Тайлант онд төлбөрт үйлчилгээний орлого 599.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс нийт 321.0 мянган төгрөгийг бэлнээр хүлээн авч төвлөрүүлсэн, 278.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1 "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2 "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна", 3.6.6 "Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна"; 3.6.10 "Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" 3.6.8. "Төсвийн байгууллага нь ЖМС-ийн хөрөнгийн зарцуулалтын тайланг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гарган картын дансны дэлгэрэнгүй хуулга, холбогдох үндэслэх баримтын хамт харьяа төрийн санд хүргүүлэн дараагийн ЖМС авах эрхээ нээлгэж болно".	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Шат шатны хяналт сул.	
Үр нөлөө: Орлого дутуу төвлөрүүлэх, хувьдаа завших нөхцөл бүрдэнэ.	
Албан шаардлага: Төрийн сангийн ЖМС-ын данс нээлгэн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг бүрэн төвлөрүүлэх, орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан тушааж, зарцуулалтын тайланг журамд заасны дагуу гаргах, цаашид үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг бэлнээр хураан авч төвлөрүүлэхгүй байх зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.	

<b>Илэрсэн асуудал 2</b>	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй нийт 10,929.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Шинээр худалдан авсан 7,066.6 мянган төгрөг, хандиваар 3,862.8 мянган төгрөг нийт 10,929.4 мянган төгрөгийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, данс бүртгэл тусгах тушаал шийдвэргүйгээр хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 65 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж, төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна” заалтуудад нийцээгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Шат шатны хяналт сул.	
Үр нөлөө: Хууль, дүрэм журам зөрчигдөнө. Аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж авах эрсдэл үүснэ.	

Зөвлөмж: “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг гаргуулан, данс бүртгэлд тусгах тушаал шийдвэр гарган хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж байх.

<b>Илэрсэн асуудал 3</b>	Дотоод хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу удирдамж баталсан боловч хяналт шалгалтыг иж бүрэн гүйцэтгээгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.1 "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах"	
Асуудлын үндсэн шалтгаан: Хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлээгүй.	
Үр нөлөө: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
Зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах. Илэрсэн алдаа дутагдлыг арилгуулан үр дүнг хамт олонд мэдээлж байх.	

<b>Илэрсэн асуудал 4</b>	Шилэн дансны цахим системд 2 мэдээ хугацаа хоцроосон. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 13 тушаалаар нийт 11,908.8 мянган төгрөгийн зардал гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай.
Бодит байдал: 2 мэдээлэл хугацаа хоцроосон. 13 тушаалаар нийт 11,908.8 мянган төгрөгийн зардал гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр".	
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө: Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
Зөвлөмж: Давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.	

## 6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тус байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд төсөв, санхүүг захиран зарцуулсан байна. Хяналт шалгалтын явцад үндсэн үйл ажиллагаанаас олсон төлбөрт үйлчилгээний орлогыг бэлнээр хураан авч, төвлөрүүлдэг. Мөн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, тус зөвлөлийн хурлын шийдвэргүй хөрөнгө данс бүртгэлд бүртгэсэн асуудал илэрлээ.

Цаашид холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөн ажиллах, үндсэн үйл ажиллагаанаас олсон орлоготой холбоотой бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай болох,

төрийн сангийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа болон дотоод хяналтыг сайжруулах, хяналт шалгалтаар илэрсэн асуудлыг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Иймд *“Аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудын 25 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн үед өгдөг “Сайжруулах шаардлагатай” үнэлгээг өгөв.*

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ